

試験回答

Хариу

Эхний хэсэг パート 1 (150点)

- Дүрэм 文法 (100点)
- Эх уншлага 読解 (50点)

Хоёрдугаар хэсэг パート 2 (100点)

- Сонсгол 聴解 (50点)
- Зохион бичлэг 作文 (50点)

“Нутаг” Монгол хэлний сургууль
Япон улс, Токио хот
2020 оны 11 сарын 21

Дүрэм 文法 (100点)

A 単語 (15問×1点=15点)

下記の単語を日本語に直してください。

1. Ногоо	<u>野菜、緑</u>	9. Зузаан	<u>厚い</u>
2. Өнөө өглөө	<u>今朝</u>	10. Цэнхэр	<u>水色</u>
3. Ирэх сар	<u>来月</u>	11. Амттай	<u>美味しい</u>
4. Банк	<u>銀行</u>	12. Бид нар	<u>私たち</u>
5. Цээжлэх	<u>覚える</u>	13. Анх удаа	<u>初回</u>
6. Уулзах	<u>会う</u>	14. Бүгд	<u>全部、全て</u>
7. Ажиллах	<u>働く</u>	15. Бараг	<u>おおよそ</u>
8. Гүйх	<u>走る</u>		

B. 【疑問詞】(10問×2点=20点)

下記の疑問詞を含む文を日本語に直してください。

1. Үүнийг хаанаас авсан бэ? これは、どこから買いましたか?
2. Таны хүү хэдэн настай вэ? あなたの息子は何歳ですか?
3. Та хэзээ Монголд ирэх вэ? あなたは、いつモンゴルに来ますか?
4. Энэ гутлыг хэдэн төгрөгөөр авсан бэ? この靴を何トウグルグで買いましたか?
5. Чи ямар хоолонд дуртай вэ? あなたはどんな料理が好きですか?
6. Ким аль улсын иргэн бэ? 金さんはどの国の国民ですか?
7. Энд юу гэж бичсэн байна вэ? ここで何と書いてありますか?
8. Үдэшлэгт хэчнээн хүн ирэх вэ? パーティーに何人(ぐらい)来ますか?
9. Та маргааш Токио руу юугаар явах вэ? あなたは明日、何で東京に来ますか?
10. Гэрийг яаж барьдаг вэ? ゲルをどのように建てますか?

C. 【数字】(5問×2点=10点)

下記の下線部分をモンゴル語で書いてください。

例: 私は週に2回ノタッグへ来ます。 хоёр удаа

1. Доржさんの電話番号は99 45 66 98です。 Ерэн ес дөчин тав жаран зургаа ерэн найм
2. 私は1993年11月21日生まれです。 Мянга есөн зуун ерэн гурван оны арван нэгдүгээр сарын хорин нэгэн
3. 4本のボールペンを買いました。 Дөрвөн ширхэг бал
4. 鈴木さんの部屋は5階です。 Таван давхар
5. そのコップを5580トウグルグで買いました。 Таван мянга таван зуун наян төгрөг

D. 【動詞の活用】 (10問×3点=30点)

下記の「**сурах**」という動詞を含む文をモンゴル語に直してください。

例文: 私はモンゴルを習ってます。

Би Монгол хэл сурч байна.

1. 私はモンゴル語を習いたいです。 Би Монгол хэл сурмаар байна
2. 私はモンゴル語を習いました。 Би Монгол хэл сурчихсан/сурсан
3. 私はモンゴル語を習わないです。 Би Монгол хэл сурдаггүй
4. Монゴル語を習いましょう。 Монгол хэл суръя/сурцгаая
5. Уланбаатрへモンゴル語を学びに行きました。 Монгол хэл сурахын тулд Улаанбаатар явсан
6. Монゴル語を学んだら、モンゴルへ旅行したいです。 Монгол хэл сурсны дараа Монгол руу аялахаар явмаар байна
7. 私は2年間モンゴル語を勉強しています。 Би хоёр жил Монгол хэл сурч байна
8. 大学に入るためにモンゴル語を習わなければいけない。 Их сургуульд орохын тулд Монгол хэл сурахгүй бол болохгүй/сурах ёстой
9. 私は来年の春からモンゴル語を勉強します。 Би дараа жилийн хавраас Монгол хэл сурна
10. 私は小さい時にモンゴル語を勉強していました。 Би багаасаа Монгол хэл сурч байсан.

E. 【語順】 (5問×2点=10点)

下記の文を正しい順に直してください。

- 1 · Манай багшийн нэрийг Цолмон гэдэг
- 2 · Би орой болгон зурагтын мэдээ үздэг
- 3 · Болдын ах гурван өдрийн дараа Монголоос ирнэ.
- 4 · Гэрийн даалгавараа маргаашаас өмнө дуусгахгүй бол болохгүй.
- 5 · Дарга яг одоо ажил дээрээ байхгүй байгаа бололтой.

Хуудас {

F. 【人称代名詞】 (5問×1点=5点)

下記の下線部分をモンゴル語に直してください

1. これは私の本です。 Миний
2. これはあなたにもらった本です。 Танаас
3. 彼女にこの本を渡してください。 Тэр эмэгтэйд
4. 私と一緒にこの本を読みますか。 Надтай
5. 彼らと会いましょう。 Тэдэнтэй

G. 【助詞】 (10問×1点=10点)

下記の空欄に助詞を書いてください。

例: モンゴルの夏 Монгол(ын) зун

1. Мод(ны) навч 木の葉っぱ
2. Их дэлгүүр(ээс) авсан Деパートで買った
3. Гэр(т) амьдардаг Гелに住んでいる
4. Гар(аар) бичих 手で書く
5. Найз(тай) уулзах 友達と会う
6. Ном(ын) сан 図書館
7. Хол(оос) ирэх 遠くから来る
8. Онгоц(оор) явах 飛行機で行く
9. Цаас(аар) хийсэн 紙で作った
10. Багш(ийг) дуудах 先生を呼ぶ

Сонсгол 聽解 (50点)

(1) (10問×1点=10点)

1. Чи одоо (явлаа) юу?
2. Үүнийг (монголоор) юу гэдэг вэ?
3. Та яагаад ийм (үнэтэй) юм авсан бэ?
4. Би удахгүй (гучин) нас хүрнэ.
5. Манай нялх хүүхэд (орон) дээр сайхан унтаж байна.
6. Ноднин намар Монголд монгол хэлний шинэ (толь) гарсан гэнэ.
7. Бид одоо (гадаад) сайхан амьдарч байна.
8. Та нар одоо (унтлаа) юу?
9. Дараагийн дараа жил (худалдааны) татвар нэмэгдэнэ гэнэ.
10. Жил бүр гадаадаас хэдэн арван мянган (жуулчид) Монголд очдог.

(2) (14問×1点=14点)

1. Энэ (тухай) багш чи бид (гурав) л мэднэ.
2. Гадаа маш хүйтэн, хасах (хорин) (дөрвөн) хэм байна.
3. Бид маргааш (есөн) цагаас арван таван цаг (хүртэл) хичээлтэй.
4. Манай гэрийн утасны (дугаар) дөчин тав, (арван) (найм) хорин ес.
5. Та нар мянга есөн (зуун) наян зургаан онд (төрсөн) юм уу?
6. Тэр хүн сард (арван) зуун (хорин) мянган иений (цалин) авдаг гэнэ.

(3) (17問×1点=17点)

Үндэстний Түүхийн Музей нь төрийн ордны (баруун), хувьсгалчдын (гудамжинд) байдаг. Тус музей нь өдөр бүр арваас арван (зургаан) цаг хүртэл ажилладаг.

Та бүхэн долоо хоногийн аль ч өдөр очиж (үзэж) болно. Үндэстний түүхийн музейг мянга (есөн) зуун хорин дөрвөн онд байгуулжээ. Энэ музей нь (түүх) , археологи, угсаатны газарзүйн (дөчин) зургаан (мянга) гаруй үзмэртэй. Анх Европ -Азийн тал (нутагт) анхны хүн ирж суурьшсанаас хойш одоог (хүртэл) үеийн олон (үзмэрийг) долоон том танхимд (дэлгэн) үзүүлжээ. Том хүний тасалбар хоёр мянга таван зуун (төгрөг). Гэр (бүлийн) тасалбар гурван мянган төгрөгийн (үнэтэй). Харин хүүхэд гурван (зуун) төгрөг , оюутан бол таван зуун төгрөг (төлөөд) үзэж болно.

(4) (9問×1点=9点)

1. Төрийн хэлхээ (хууль), төрлийн хэлхээ (нагац)
2. Монгол орон өвөл, (хавар), зун, (намар) гэсэн (дөрвөн) улиралтай.
3. (Ороо) морь уургаар, (ууртай) хүнийг аргаар
4. Өөдлөхөд (омогших) муу, уруудахад (гэмших) муу.

Эх уншлага 読解 (1) 20点

Батнасан өнөө орой ажлаа тараад жижиг хүнсний дэлгүүр орно. Тэр алим жимс, бас сүү тараг, амттай талх авав. Тэгээд тэр гэртээ хариад багахан цай ууж амраад оройн хоолоо хийж эхлэв. Тэр гурилтай шөлөнд маш дуртай. Бас сүүтэй цай чанана. Хоолоо идээд аяга тавгаа угаана. Дараа нь өчигдөр угаасан цамцаа индүүднэ. Зурагтаар дуртай киногоо хараад усанд орж унтах болов. Батнасан орой болгон 10:00 цагт унтдаг. Маргааш өглөө эрт 6 цагаас босч дасгал хийсний дараа ажилдаа явна.

Зөв(✓), буруу(✗) аль нь вэ? (10問×2点=20点)

- (✗)1 Тэр харих замдаа том дэлгүүрт орсон.
- .
- (✗)2 Тэр дэлгүүрээс загас, мах, ногоо авсан.
- .
- (✓)3. Тэр гурилтай шөлөнд дуртай.
- (✗)4 Тэр зоогийн газар орж хоол идсэн.
- .
- (✗)5 Тэр хоолоо идээд шууд унтсан.
- .
- (✓)6. Тэр хоолоо идээд аяга тавгаа угаасан.
- (✗)7 Тэр зурагтаар сонин мэдээ үзсэн.
- .
- (✓)8. Тэр 22 цагт унтдаг.
- (✗)9 Маргааш амралтын өдөр.
- .
- (✗)10. Батнасан өглөө 6 цагаас ажилдаа явна.

Эх уншлага 読解 (2) 30点**Монголчуудын зочлох ёсноос**

Монголчууд аливаа газрын ёс заншлыг хүндэлж хандах талаар “Усыг нь уувал ёсыг нь дага” гэдэг.

Монгол хүн баруун талыг “Сайн, зөв, хүчтэй, илүү, дээд” гэж эрхэмлэдэг тул зочин хүн айлд орохдоо баруун хөлөөрөө эхэлж алхаж ордог ёстой. Харин зүүн хөлөөрөө эхэлж алхаж орвол өр нэхэх, заргалдах хүн байна гэж ойлгодог юм. Мөн зочин хүн хувцсаа засаж, товчоо бүрэн товчилж орох ёстой. Ахмад хүн зочилж ирвэл айлын хүн хаалгаа нээж зочныг эхлээд оруулдаг.

Зочин айлд ороод мэндлэхэд гэрийн эзэн хариу мэндлэн ахмад зочны гадуур хувцсыг авч өлгөөд “Та дээшээ суу!”, “За ийшээ суу!” гэх мэтээр суудал зааж өгдөг. Олон зочин бол насныхаа эрэмбээр суух ёстой.

Гэрийн эзэгтэй цай аягалахдаа нар зөв эргэлттэйгээр хийгээд эхлээд нөхөртөө, дараа нь зочиндоо хоёр гардан барина. Цайг аягалах үедээ амьсгалаа оруулахаас цээрлэдэг ба данхны цоргыг үүд рүү харуулж тавьдаггүй. Настай хүнд бол зориуд аагтай цай чанаж барих нь бий. Зочинд сэтэрхий аяганд хоол, цай хийж өгдөггүй. Зүүн аймгийнхан давсгүй, баруун аймгийнхан давс ихтэй, өтвөн цай уудаг онцлогтой. Зочин хүн тавагтай идээнээс амсахдаа зүүн гарынхаа алгыг дээш харуулан, дунд хурууныхаа өндгөөр тавагт хүрч, баруун гараараа идээнээс авч амсана.

Цай, хоол болж байхад зочин ирвэл “Та морьтой явж байна” (Та азтай байна) гэж бэлгэшээн хэлдэг. Зочин хүн чихэр жимс, нарийн боов, сүү цагаан идээ гэх мэтийн зүйлийг гарын бэлэг болгон авч очоод айлын эзэгтэйд хоёр гардан өгөх ёстой.

Монгол хүүхдүүн зочин байхад зочны урдуур хойгуур гүйж шуугих, том хүмүүсийн ярианд оролцдоггүй. Зочин явах үед гэрийн хүн эхэлж гарч, араас нь зочин гардаг ёстой. Гэрийн эзэгтэй удаан уулзаагүй, холоос ирсэн зочныг явах үед нь бэлэг өгдөг. Их хүндтэй айлаас ухран гардаг. Настай болон хүндтэй зочныг явах үед унаанд суулган үдэж өгөх ёстой.

Зөв(✓) үү, буруу(✗) юу? (6問×5点=30点)

- (✗) 1. Монгол айлд орохдоо зүүн хөлөөрөө эхлэж алхан орвол их сайн гэж үздэг.
- (✗) 2. Гэрийн эзэгтэй бүх зочинд бэлэг өгөх ёстой.
- (✓) 3. Удаан хугацаагаар уулзаагүй зочинд бэлэг өгдөг.
- (✓) 4. Гэрийн эзэгтэй цай аягалаад эхлээд нөхөртөө, дараа нь зочинд өгдөг.
- (✗) 5. Зочноо хүндлэн данхны цоргоо үүд рүү харуулан тавьдаг.
- (✗) 6. Мориор ирсэн зочныг азтай байна гэж хүндэлдэг.

Хуудас {